

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн  
гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ГАА-2026/176/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Алтай хот 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Цэрэнханд Утас: 99086371 Цахим хаяг: atartsetsegm@audit.gov.mn Аудитор: Н.Гэрэлмаа Утас: 99782918 Цахим хаяг: gerelmaan@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр) .....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр) .....	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр) .....	5
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр) .....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр) .....	7
2.6 Нэмэлт санхүүжилтийн тайлан (төгрөгөөр) .....	9
<b>3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....</b>	<b>9</b>
3.1 Залруулсан алдаа:.....	9
3.3 Зөвлөмж .....	11
<b>Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....</b>	<b>26</b>



## ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,  
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091  
Утас: (976) 7048-4030,  
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2026.02.24

№

89

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН  
ДАРГА Ж.ОЧИР ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр “Хязгаарлалттай” санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй. Үүнд:

- Байгууллагын даргын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/54 дүгээр тушаалаар албан хаагчдад олгох унаа, хоолны зардлын хэмжээг 20.0 мянган төгрөг болгон баталсан боловч тушаалд хөнгөлөлтийг 10, 11 дүгээр саруудаас эхлэн олгохоор тусган 6,804.5 мянган төгрөгийг илүү тооцож олгосон,
- Байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар олгосон дарш бэлтгэх болон бусад сургалт арга хэмжээний зардал 2,665.0 мянган төгрөгийг анхан шатны баримт дутуу байхад гүйлгээ хийсэн,

822505000240

- Санхүүгийн тайланд тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нийгмийн даатгалын шимтгэлийн 10,369.0 мянган төгрөгийн, ХАОАТ-ын 5,361.9 мянган төгрөгийг илүү тооцон шилжүүлж нийт 15,730.9 мянган төгрөгийн авлага үүсгэсэн байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 16.5.7 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.5 дахь заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тус байгууллагын улсын төсвийн санхүүжилт өмнөх оноос 70,930.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас 18,588.6 мянган төгрөгийн 7 ширхэг компьютер, бусад эх үүсвэрээс 207,428.5 мянган төгрөгийн бараа материал бэлтгэсэн байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд төсвийн захирагчийн 5 зорилтын хүрээнд 48 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 42 арга хэмжээ бүрэн, 6 арга хэмжээг 70.0 хүртэл хувиар хэрэгжүүлж, нийт дүнгээр 94.8 хувиар биелэлтийг хүргүүлсэн боловч дээд шатны байгууллагаас ажлыг дүгнээгүй байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>476,441,467.83</b>	<b>477,890,191.69</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	8,892,904.00	24,573,397.86
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	8,892,904.00	24,573,397.86
33510	Байгууллагаас авах авлага	8,892,904.00	24,573,397.86
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	209,048,563.83	403,316,793.83
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	160,048,563.83	304,316,793.83
35410	Бичиг хэргийн материал	4,440,880.00	2,478,810.00
35420	Аж ахуйн материал	154,859,083.83	301,528,983.83
35430	Сэлбэг хэрэгсэл	309,000.00	309,000.00
35440	Түлш, шатах тослох материал	439,600.00	-
35600	Мал амьтад	49,000,000.00	99,000,000.00
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	258,500,000.00	50,000,000.00
36300	Тэжээлийн нөөц	258,500,000.00	50,000,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>808,100,970.40</b>	<b>745,308,764.66</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	808,100,970.40	745,308,764.66
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	702,280,970.24	639,708,764.66
39201	Барилга, байгууламж, орон сууц	437,505,311.00	437,505,311.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(95,683,562.48)	(104,520,336.56)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	525,844,389.00	525,844,389.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(362,408,108.02)	(403,586,700.70)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	144,504,300.83	163,092,870.83
39206	Хуримтлагдсан элэгдэл	(92,766,914.33)	(103,643,921.99)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	22,294,588.40	22,294,588.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	(19,347,684.31)	(19,965,557.47)
39214	Бусад үндсэн хөрөнгө	180,438,811.77	180,438,811.77
39215	Хуримтлагдсан элэгдэл	(38,100,161.62)	(57,750,689.62)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	105,820,000.16	105,600,000.00
39301	Програм хангамж	7,000,000.00	7,000,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(6,779,999.84)	(7,000,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	105,600,000.00	105,600,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,284,542,438.23</b>	<b>1,223,198,956.35</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>10,189,800.28</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	10,189,800.28
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	10,189,800.28
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	1,261,300.28
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	-	8,928,500.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	80,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	8,848,500.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,284,542,438.23</b>	<b>1,213,009,156.07</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,284,542,438.23	1,213,009,156.07
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	723,241,635.93	723,241,635.93
51101	Өмч: - төрийн	723,241,635.93	723,241,635.93
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	373,302,550.40	301,769,268.24
51210	Өмнөх үеийн үр дүн	530,816.69	373,302,550.40
51220	Тайлант үеийн үр дүн	372,771,733.71	(71,533,282.16)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	187,998,251.90	187,998,251.90
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,284,542,438.23</b>	<b>1,223,198,956.35</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

**(төгрөгөөр)**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,735,206,951.15</b>	<b>1,247,078,598.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>234,763,287.35</b>	<b>226,017,070.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	234,763,287.35	226,017,070.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	13,892,904.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13,892,904.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	144,346,501.54	18,588,570.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	76,523,881.81	207,428,500.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,500,443,663.80</b>	<b>1,021,061,528.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,028,597,900.00	916,964,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,028,597,900.00	916,964,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	471,845,763.80	104,097,528.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	2,290,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	459,688,963.80	95,896,396.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,156,800.00	3,523,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	2,387,732.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,362,435,217.44</b>	<b>1,318,611,880.16</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,362,435,217.44</b>	<b>1,318,611,880.16</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,250,970,226.62	1,268,152,208.41
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	650,233,952.24	681,075,799.13
210101	Үндсэн цалин	358,711,992.33	351,432,567.34
210102	Нэмэгдэл	256,614,291.00	224,676,659.79
210103	Унаа хоолны хөнгөлөлт	32,518,759.00	53,054,988.00
210104	Урамшуулал	2,388,909.91	51,911,584.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	84,848,400.00	91,139,102.32
210201	Тэтгэврийн даатгал	60,896,899.89	62,316,902.32
210202	Тэтгэмжийн даатгал	5,987,800.11	6,905,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,993,900.00	3,752,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,993,900.00	3,752,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,975,900.00	14,410,900.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	19,889,341.74	23,503,159.18
210301	Гэрэл, цахилгаан	2,240,193.79	2,697,256.08
210302	Түлш, халаалт	16,619,987.95	18,240,209.86
210303	Цэвэр, бохир ус	1,029,160.00	2,565,693.24
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	104,374,972.00	33,950,122.04
210401	Бичиг хэрэг	5,742,950.00	3,227,070.00
210402	Тээвэр, шатахуун	25,449,716.00	15,783,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,468,776.00	2,260,552.04
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	70,473,530.00	12,439,100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	10,726,500.00	29,537,000.00
210604	Урсгал засвар	10,726,500.00	29,537,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	19,130,900.00	17,762,600.00
210702	Дотоод албан томилолт	19,130,900.00	17,762,600.00

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	286,389,196.33	100,564,650.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	277,699,909.33	93,622,650.00
210803	Даатгалын үйлчилгээ	138,435.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	164,252.00	192,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,500.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,640,000.00	5,400,000.00
210807	Газрын төлбөр	636,100.00	1,350,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	75,376,964.31	290,619,775.74
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,587,250.00	209,239,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	73,789,714.31	81,380,775.74
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	111,464,990.82	50,459,671.75
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	96,987,996.00	2,100,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,385,000.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	90,977,996.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	625,000.00	2,100,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	14,476,994.82	48,359,671.75
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,476,431.02	27,743,289.75
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	5,000,563.80	20,616,382.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>372,771,733.71</b>	<b>(71,533,282.16)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>372,771,733.71</b>	<b>(71,533,282.16)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,505,443,663.80</b>	<b>1,029,954,432.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,505,443,663.80</b>	<b>1,029,954,432.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,028,597,900.00	916,964,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,028,597,900.00	916,964,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	476,845,763.80	112,990,432.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	2,290,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	459,688,963.80	95,896,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,156,800.00	3,523,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,000,000.00	11,280,532.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,505,443,663.80</b>	<b>1,029,954,432.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,505,443,663.80</b>	<b>1,029,954,432.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,393,978,672.98</b>	<b>979,494,760.25</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	650,233,952.24	700,525,899.31
210101	Үндсэн цалин	348,027,459.77	396,279,384.00
210102	Нэмэгдэл	219,217,687.35	193,218,196.01
210103	Унаа хоолны хөнгөлөлт	32,518,759.00	57,512,981.75
210104	Урамшуулал	50,470,046.12	53,515,337.55
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	84,848,400.00	87,419,900.00
210201	Тэтгэврийн даатгал	60,896,900.00	58,597,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,987,800.00	6,905,500.00

Говь-Алтай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210203	ҮОМШӨ-ний даатгал	2,993,900.00	3,752,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,993,900.00	3,752,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,975,900.00	14,411,200.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	20,215,207.74	22,505,010.94
210301	Гэрэл, цахилгаан	2,240,193.79	2,697,256.08
210302	Түлш, халаалт	16,945,853.95	18,240,209.86
210303	Цэвэр, бохир ус	1,029,160.00	1,567,545.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	25,197,876.00	18,674,300.00
210401	Бичиг хэрэг	5,253,500.00	1,222,000.00
210402	Тээвэр, шатахуун	16,320,600.00	14,242,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,468,776.00	2,034,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	160,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	915,000.00	1,015,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	94,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	94,000.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	24,603,400.00	29,537,000.00
210604	Урсгал засвар	10,533,500.00	29,537,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	15,226,900.00	17,762,600.00
210702	Дотоод албан томилолт	15,226,900.00	17,762,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	571,971,687.00	101,666,050.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	563,282,400.00	94,724,050.00
210803	Даатгалын үйлчилгээ	138,435.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	164,252.00	192,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,500.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,640,000.00	5,400,000.00
210807	Газрын төлбөр	636,100.00	1,350,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1,587,250.00	1,404,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,587,250.00	1,404,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>111,464,990.82</b>	<b>50,459,671.75</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	96,987,996.00	2,100,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,385,000.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	90,977,996.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	625,000.00	2,100,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	14,476,994.82	48,359,671.75
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,476,431.02	27,743,289.75
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	5,000,563.80	20,616,382.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	=	=
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	-

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

**(төгрөгөөр)**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	723,241,635.93	187,998,251.90	530,816.69	911,770,704.52
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	723,241,635.93	187,998,251.90	530,816.69	911,770,704.52
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	372,771,733.71	372,771,733.71
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	723,241,635.93	187,998,251.90	373,302,550.40	1,284,542,438.23
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	723,241,635.93	187,998,251.90	373,302,550.40	1,284,542,438.23
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	723,241,635.93	187,998,251.90	373,302,550.40	1,284,542,438.23
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(71,533,282.16)	(71,533,282.16)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	723,241,635.93	187,998,251.90	301,769,268.24	1,213,009,156.07

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**(төгрөгөөр)**

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	941,302,500.00	889,220,710.25	52,081,789.75	94.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	941,302,500.00	889,220,710.3	52,081,789.8	94.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	925,799,900.00	887,120,710.25	38,679,189.8	95.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	729,371,100.00	700,525,899.31	28,845,200.7	96.0
210101	Үндсэн цалин	440,378,700.00	396,279,384.00	44,099,316.0	90.0
210102	Нэмэгдэл	222,961,700.00	193,218,196.01	29,743,504.0	86.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	35,208,000.00	57,512,981.75	(22,304,981.8)	163.4
210104	Урамшуулал	30,822,700.00	53,515,337.55	(22,692,637.6)	173.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	87,419,900.00	87,419,900.00	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	58,597,400.00	58,597,400.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	6,905,500.00	6,905,500.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,752,900.00	3,752,900.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	3,752,900.00	3,752,900.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	14,411,200.00	14,411,200.00	-	100.0

<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	22,572,700.00	22,505,010.94	67,689.1	<b>99.7</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,051,900.00	2,697,256.08	1,354,643.9	<b>66.6</b>
210302	Түлш, халаалт	16,541,800.00	18,240,209.86	(1,698,409.9)	<b>110.3</b>
210303	Цэвэр, бохир ус	1,979,000.00	1,567,545.00	411,455.0	<b>79.2</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	17,860,000.00	15,820,300.00	2,039,700.0	<b>88.6</b>
210401	Бичиг хэрэг	1,747,000.00	1,222,000.00	525,000.0	<b>69.9</b>
210402	Тээвэр, шатахуун	12,160,500.00	11,388,400.00	772,100.0	<b>93.7</b>
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,149,100.00	2,034,400.00	114,700.0	<b>94.7</b>
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	770,000.00	160,000.00	610,000.0	<b>20.8</b>
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,033,400.00	1,015,500.00	17,900.0	<b>98.3</b>
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	29,537,800.00	29,537,000.00	800.0	<b>100.0</b>
210604	Урсгал засвар	29,537,800.00	29,537,000.00	800.0	<b>100.0</b>
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	18,300,000.00	13,946,600.00	4,353,400.0	<b>76.2</b>
210702	Дотоод албан томилолт	18,300,000.00	13,946,600.00	4,353,400.0	<b>76.2</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	18,936,500.00	16,412,000.00	2,524,500.0	<b>86.7</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,477,200.00	9,470,000.00	7,200.0	<b>99.9</b>
210803	Даатгалын үйлчилгээ	609,200.00	-	609,200.0	<b>0.0</b>
210804	Тээврийн хэрэгслийн татвар	192,600.00	192,000.00	600.0	<b>99.7</b>
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	107,500.00	-	107,500.0	<b>0.0</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,200,000.00	5,400,000.00	1,800,000.0	<b>75.0</b>
210807	Газрын төлбөр	1,350,000.00	1,350,000.00	-	<b>100.0</b>
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1,801,900.00	954,000.00	847,900.0	<b>52.9</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,431,900.00	954,000.00	477,900.0	<b>66.6</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	370,000.00	-	370,000.0	<b>0.0</b>
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	15,502,600.00	2,100,000.00	13,402,600.00	<b>13.5</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	15,502,600.00	2,100,000.00	13,402,600.0	<b>13.5</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	11,447,900.00	-	11,447,900.0	<b>0.0</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,054,700.00	2,100,000.00	1,954,700.0	<b>51.8</b>
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>941,302,500.00</b>	<b>889,220,710.25</b>	<b>52,081,789.8</b>	<b>94.5</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	941,302,500.00	889,220,710.25	52,081,789.8	<b>94.5</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	941,302,500.00	889,220,710.25	52,081,789.8	<b>94.5</b>

## 2.6 Нэмэлт санхүүжилтийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>112,990,432.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	112,990,432.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	92,374,050.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2,854,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,854,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	3,816,000.00
210702	Дотоод албан томилолт	3,816,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	85,254,050.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	85,254,050.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	450,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	450,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	20,616,382.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	20,616,382.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,616,382.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>112,990,432.0</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	112,990,432.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25,030,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	79,117,932.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,842,500.00

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 3,869.4 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа<sup>1</sup>-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

### 3.1 Залруулсан алдаа:

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Үр дүнгийн тайланд тээвэр шатахууны зардлыг 1,101.4 мянган төгрөгөөр, бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлийн зардлын 665.0 мянган төгрөгөөр тус тус илүү, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 1,101.4 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 665.0 мянган төгрөгөөр тус тус дутуу тайлагнасныг залруулсан.
- Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 1,942,403.9 мянган төгрөгийн 104 мэдээллээс бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн нийт 2,100.0 мянган төгрөгийн 6 мэдээллийг мэдээлээгүйг нөхөн байршууллаа.

Залруулагдаагүй нийт 25,200.4 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Нийт 25,200.4 мянган төгрөгийн 4 зөрчил<sup>2</sup> илэрсэнд 3 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлсэн.

### 3.2 Албан шаардлага

Нэг. Байгууллагын даргын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/54 дүгээр тушаалаар албан хаагчдад олгох унаа, хоолны зардлын хэмжээг 20.0 мянган төгрөг болгон баталсан боловч тушаалд хөнгөлөлтийг 10, 11 дүгээр саруудаас эхлэн олгож 6,804.5 мянган төгрөгийг илүү тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад" гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хоолны хөнгөлөлт шинэчлэн олгосон шийдвэрийг дахин хянаж төсвийн хүрээнд зарлага гаргах албан шаардлага хүргүүлсэн.

Хоёр. Санхүүгийн тайланд тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нийгмийн даатгалын шимтгэлд 10,369.0 мянган төгрөгийн, ХАОАТ-т 5,361.9 мянган төгрөгийг илүү тооцон шилжүүлж нийт 15,730.9 мянган төгрөгийн авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "Байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлагын тооцоог нийлж баталгаажуулаагүй, барагдуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

Гурав. Тайлант онд ажлаас чөлөөлөгдсөн 4 ажилтанд амралтын цалингийн дуусгалтын тооцоо хийгээгүй нь Хөдөлмөрийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1-т "Ажил олгогч ажилтны ажлын байрыг хэвээр хадгалах тохиолдолд ажлыг нь түр, хөдөлмөр эрхлэлтийн харилцаа дуусгавар болсон тохиолдолд бүрмөсөн хүлээн авна", 110 дугаар зүйлийн 110.3-т "Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа нь дуусгавар болж байгаа ажилтанд ажилласан хугацаанд ногдох ээлжийн амралтын тооцоо хийж, цалинг олгоно", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/191 дүгээр тушаалын хавсралт "Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам"-ын 2.8-т "Ажилтны хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцлах, дуусгавар болгох үед ажил олгогч нь ажилтантай ээлжийн амралтын тооцоог дараах байдлаар хийнэ. Үүнд: ажилтанд ажилласан хугацаанд нь ногдох ээлжийн амралтын цалинг олгох; ажилтнаас илүү олгосон ээлжийн амралтын цалингийн суутгалыг хийх" гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажлаас чөлөөлөгдсөн ажилтнуудтай дуусгалтын тооцоог хийгээгүй зөрчлийг арилгах шаардлага хүргүүлсэн.

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### Нэг. Төсвийн зарцуулалттай холбоотой

Илрүүлэлт: Байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар олгосон дарш бэлтгэх болон бусад сургалт арга хэмжээний зардал болох 2,665.0 мянган төгрөгийн анхан шатны баримт дутуу байхад гүйлгээ хийсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх, баримт дутуу хийсэн зардлын зарцуулалтад хяналт хэрэгжүүлэх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Говь-Алтай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөг)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж			
		Тоо		Дүн		Тоо		Дүн		Залруулсан		Залруулааг үй		Тоо	
		3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14		
	Үр дүнгийн тайланд тээвэр шатахууны зардлыг 1,101.4 мянган төгрөгөөр, бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлийн зардлын 665.0 мянган төгрөгөөр тус тус илүү, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 1,101.4 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 665.0 мянган төгрөгөөр тус тус дутуу тайлагнасан.	1	1,769.4	-	-	1	1,769.4	1	1,769.4	-	-	-	-		
Хүнс, хөдөө аж ахуйн газар	Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 1,942,403.9 мянган төгрөгийн 104 мэдээллээс бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн нийт 2,100.0 мянган төгрөгийн 6 мэдээллийг мэдээлээгүй байна.	1	2,100.0	1	2,100.0	-	-	1	2,100.0	-	-	-	-		
	<b>Дүн</b>	<b>2</b>	<b>3,869.4</b>	<b>1</b>	<b>2,100.0</b>	<b>1</b>	<b>1,769.4</b>	<b>2</b>	<b>3,869.4</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>		

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2 Байгууллагын даргын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/54 дүгээр тушаалаар албан хаагчдад олгох унаа, хоолны зардлын хэмжээг 20.0 мянган төгрөг болгон баталсан боловч тушаалд хөнгөлөлтийг 10, 11 дүгээр саруудаас эхлэн олгохоор тусган 6,804.5 мянган төгрөгийг илүү тооцож олгосон байна.	3	4	5	6	7	8	9	10	11	12
		1	6,804.5	-	-	1	6,804.5	-	-	-	-
Хүнс, хөдөө аж ахуйн газар	Байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар олгосон дарш бэлтгэх болон бусад сургалт арга хэмжээний зардал болох 2,665.0 мянган төгрөгийн анхан шатны баримт дутуу байхад гүйлгээ хийсэн байна.	1	2,665.0	-	-	-	-	1	2,665.0	-	-
	Санхүүгийн тайланд тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нийгмийн даатгалын шимтгэлийн 10,369.0 мянган төгрөгийн, ХАОАТ-ын 5,361.9 мянган төгрөгийг илүү тооцон шилжүүлж нийт 15,730.9 мянган төгрөгийн авлага үүсгэсэн байна.	1	15,730.9	-	-	1	15,730.9	-	-	-	-
	Тайлант онд ажлаас чөлөөлөгдсөн 4 ажилтанд амралтын цалингийн дуусгалтын тооцоо хийгээгүй.	1	-	-	-	1	-	-	-	-	-
	<b>Дүн</b>	<b>4</b>	<b>25,200.4</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>3</b>	<b>22,535.4</b>	<b>1</b>	<b>2,665.0</b>	<b>-</b>	<b>-</b>

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо					Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр				Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өрхөөс татгалзсан
		2	3	Түвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	7	8	9	10	
A	1		3	4	5		8	9	10	
1	ТШЗ		1				1			
	НИЙТ		1				1			